

“НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР” АРГА ХЭМЖЭЭ

Зохион байгуулагдах газар: Сүхбаатарын талбай

Хугацаа: 2026 оны 04 дүгээр сарын 09 – 11 өдрүүдэд

Зохион байгуулагч:

Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Эрчим хүчний яам хамтран

Оролцогч байгууллагууд:

- Ашигт малтмал, газрын тосны газар
- Үндэсний геологийн алба
- Геологийн судалгаа, шинжилгээний төв ТӨҮГ
- Цөмийн энергийн комисс
- Эрдэнэс Монгол нэгдэлийн 13 ТӨХХК

Оролцогч байгууллагууд:

- “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК
- “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК
- “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК
- “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК
- “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК
- Сэргээгдэх эрчим хүчний 14 компани

Арга хэмжээний үеэр иргэдэд үзүүлэх үндсэн үйлчилгээнүүд:

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, дүрэм журмын талаар мэдээлэл, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх;
2. Ашигт малтмалын хайгуулын аргачилсан зөвлөмж өгөх;
3. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас олгодог тусгай зөвшөөрлийн үйлчилгээний зөвлөмж, танилцуулга;
4. Ашигт малтмал, газрын тосны газраас үзүүлдэг үйлчилгээ, тусгай зөвшөөрлийн үйлчилгээний зөвлөмж, танилцуулга;
5. Үндэсний геологийн албанаас үзүүлдэг үйлчилгээ, зөвлөмж танилцуулга;
6. Цөмийн энергийн комиссын үйл ажиллагаа, танилцуулга, мэдээлэл;
7. Салбарын ТӨХХК-ний сул орон тооны мэдээлэл, ажилд орох хүсэлт гаргах зөвлөмж үйлчилгээ.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

1. Эрчим хүчний салбарын хууль тогтоомж, дүрэм журмын талаар мэдээлэл, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх
2. Цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөлийн хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх
3. Эрчим хүчний тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгах, нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой заавар, зөвлөгөө, мэдээллээр хангах
4. Эрчим хүчний шугам, тоног төхөөрөмжийн гэмтэл, доголдол болон хүчдэлийн уналттай холбоотой гомдлыг газар дээр нь бүртгэж, шуурхай бригад чиглүүлэх
5. Ухаалаг тоолуур, эрчим хүч хэмнэлтийн талаарх гарын авлага, брошюр тараах
6. Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журмын тухай

НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДРҮҮДИЙН ХӨТӨЛБӨР

НЭГДҮГЭЭР ӨДӨР: 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр (Пүрэв гараг)

10:00 - 17:00 | Иргэдэд үйлчлэх нэгдсэн цэгийн үйл ажиллагаа (Тасралтгүй явагдана)

- Бүх байгууллагууд асраараа дамжуулан иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, газар дээр нь шийдвэрлэх шуурхай үйлчилгээ үзүүлнэ.

12:00 - 12:30 | Нээлтийн үйл ажиллагаа

- Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд
- Эрчим хүчний сайд болон яамны удирдлагууд оролцож үг хэлнэ.

12:30 - 13:00 | Эрчим хүчний яамны танилцуулга

- *Сэдэв:* Эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд, салбарын бодлого төлөвлөлт.
- *Сэдэв:* Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журмын тухай танилцуулга.

13:00 - 14:00 | Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны танилцуулга

- *Танилцуулга 1:* Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын бодлого, эрхзүйн шинэчлэлийн танилцуулга
- *Танилцуулга 2:* Үндэсний геологийн алба (ГСШТ)
- *Танилцуулга 3:* Ашигт малтмал, газрын тосны газар
- *Танилцуулга 4:* Цөмийн энергийн комисс

14:00 - 14:20 | "Диспетчерийн үндэсний төв" ТӨХХК-ийн танилцуулга

- *Сэдэв:* Эрчим хүчний нэгдсэн системийн горим ажиллагаа, оргил ачааллын үеийн зохицуулалт.

ХОЁРДУГААР ӨДӨР: 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр (Баасан гараг)

10:00 - 17:00 | Иргэдэд үйлчлэх нэгдсэн цэгийн үйл ажиллагаа (Тасралтгүй явагдана)

- Иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч, тухай бүрд шийдвэрлэж зөвлөгөө мэдээлэл өгнө.

11:00 - 11:30 | "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн танилцуулга

- Сэдэв: Нийслэлийн дулаан хангамжийн хүртээмж, өвлийн бэлтгэл ажил, дулааны шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлт, хэрэглэгчдэд үзүүлэх шуурхай үйлчилгээ.

11:30 - 12:00 | "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-ийн танилцуулга

- Сэдэв: Өндөр хүчдэлийн шугам сүлжээний аюулгүй байдал, иргэдийн анхаарах сэрэмжлүүлэг, үндэсний сүлжээний найдвартай ажиллагаа.

14:00 - 14:30 | Эрдэнэс Монгол нэгдлийн танилцуулга

- Сэдэв: Эрдэнэс Монгол нэгдлийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн танилцуулга

15:30 - 16:00 | Эрдэнэс Монгол нэгдэл – “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ

- Сэдэв: “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн танилцуулга

ГУРАВДУГААР ӨДӨР: 2026 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр (Бямба гараг)

10:00 - 16:00 | Иргэдэд үйлчлэх нэгдсэн цэгийн үйл ажиллагаа (Тасралтгүй явагдана)

- Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явцыг иргэдэд танилцуулах, эцсийн байдлаар газар дээр нь шийдвэрлэх үйлчилгээ үргэлжилнэ.

10:00 - 10:30 | Эрдэнэс Монгол нэгдэл – “Эрдэнэс Таван толгой” ХК

- Сэдэв: “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн танилцуулга

10:30 - 11:30 | Эрдэнэс Монгол нэгдэл – “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК

- Сэдэв: “Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн танилцуулга

11:30 - 12:00 | "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн танилцуулга

- Сэдэв: Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчийн үйлчилгээ, ухаалаг тоолуур, цахилгааны шинэ холболт хийлгэх зааварчилгаа, цахим үйлчилгээний шинэчлэл.

13:30 - 14:00 | "Эрчим хүчний үндэсний төв" ТӨХХК-ийн танилцуулга

- Сэдэв: Эрчим хүчний барилга байгууламжид техникийн хяналт тавих, ажлын зурагт магадлал хийх, салбарын сургалт мэргэшлийн зэргийг аттестатчилах, дулаан цахилгааны тоноглолд хяналт шинжилгээ хийх, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж угсралтын зөвлөмж заавар

16:00 - 16:20 | Өдөрлөгийн хаалт

- Ажлын хэсгийн дарга Д.Батзориг нээлттэй хаалганы өдөрлөгөөр шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоон мэдээлэл, үр дүнг товч тайлагнана.
- Ажлын хэсгийн дарга М.Алтансүх нээлттэй хаалганы өдөрлөгөөр шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоон мэдээлэл, үр дүнг товч тайлагнана.

---ooOoo---